



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.01.09 № 05/507  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Н.БУДБАЯР ТАНАА


Зүг-1  
[Signature]

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төсөл хөгжлийн газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Самбуугийн Гансүх, Суурь бүтцийн газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Батдэлгэрийн Болор-Эрдэнэ, Төсөл хөгжлийн газрын Төсөл, судалгааны хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Энхбаярын Эрдэнэбат нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Б.Болор-Эрдэнэ нь “И Жи Би рэйл энд роуд” ХХК-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирлаар бүртгэлтэй, мөн эхнэр С.Батцэцэг нь тус компанийн Хамтын ажиллагааны хэлтсийн даргаар ажилладаг байх тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллана уу.

Харин 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 1/2420 дугаар албан бичгээр ирүүлсэн тус компанийн Төсөл хөгжлийн газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Б.Болор-Эрдэнэ нь өөр ажил, албан тушаалд томилогдохоор болсон тул хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг буцаан хүргүүлэв.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАН  
ДАРГА, АХЛАХ КОМИССАР



Н.ДАМДИНСҮРЭН

[Signature]  
01/12/24

142403000262